



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/149

Булган сум

### Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XII хуралдааны "Булган аймгийн 2023 оны төсөв батлах тухай" XII/21 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, төрийн алба хаагч, иргэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад чиглэсэн хууль, эрх зүйн сургалтыг зохион байгуулахад "Зөв дадал-Архигүй орчин" хөтөлбөрөөс 3,600,000 (гурван сая зургаан зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

